

3.0 Нийтлэг асуултууд

Нийтлэг асуултууд

1. Судлагдахууны дүн гэж юу вэ?

Судлагдахууны дүн гэдэг нь сургалтын төлөвлөгөөний хичээл бүрийн харьяалагдах судлагдахуунаар бүлэглэж, тогтоосон дүрмийн дагуу бодож гаргасан дүн юм. Энэ дүнг суралцагчийн суралцаж байгаа хөтөлбөрийн төгсөх буюу 9, 12-р ангиудад гаргадаг.

Анхаарах зүйлс: Боловсролын түвшингийн төгсөх ангиуд буюу 9, 12-р ангиудын судлагдахууны дүнд тухайн боловсролын түвшингийн бүх ангиудын дүн бодогдохыг анхаарна уу.

2. Судлагдахууны дүнг хэрхэн засварлаж болох вэ?

Батлагдсан **судлагдахууны дүнг** сургалтын менежерийн эрхээр цуцлах үйлдэл хийгдсэний дараа засах боломжтой.

Сургалтын менежер хичээлийн дүн цонхоор **хичээл** эсвэл **суралцагчийн нэр** мэдээлэл дээр дарж орж суралцагч, хичээлийг нь сонгож **Дүн цуцлах** товч дарсанаар уг хичээлийн дүнг засварлах боломжтой байна.

3.1 Судлагдахууны дүн бодох тохиргоо

10. 1. Судлагдахууны дүн бодох тохиргоо

Судлагдахууны дүнгийн тохиргоо болон тодруулах зүйлс байвал БСМС-ийн **75778080** утсаар ярьна уу.

3.2 Судлагдахууны дүн бодуулах ажиллагаа

10.2 Судлагдахууны дүн бодуулах ажиллагаа

Суралцагч бүрийн судалсан хичээлийг судлагдахуун бүрээр бүлэглэж, тогтоосон дүрмийн дагуу дүнг гаргах бүртгэлийн хэсэг юм. Энэ хэсэгт судлагдахуун бүрээр суралцагчийн дүнг бүртгэнэ.

Тухайн суралцагчийн суралцаж байгаа анги болон өмнөх ангиудад судалсан хичээлүүдийн жилийн эцсийн дүн, үнэлгээг бүртгэх үйл ажиллагааг энэ хэсэгт гүйцэтгэж болно.

Төгсөх ангийн хувьд анхаарах нь:

- Заавал болон сонгон судлах хичээлийн дүнг бүлгийн сурагч бүрээр бүртгэсэн байх шаардлагатай.
- Батлагдсан дүн нь төгсөх ангийн суралцагчдын хувьд судлагдахууны дүн бодоход ашиглагдана.

Суурь:

- 6, 7, 8, 9-р ангид судалсан хичээлийн дүнг нягтлах, дутуу бол нөхөж бүртгэх

Бүрэн дунд:

10, 11, 12-р ангид судалсан хичээлийн дүнг нягтлах, дутуу бол нөхөж бүртгэх

Хэрэглэгчийн эрх - Хийх үйлдлүүд

Судлагдахууны дүн бодох хэсэгт Анги удирдсан багш болон Сургалтын менежерүүд дараах үйлдлийг хийх боломжтой.

Анхаарах зүйлс

- Тухайн ангид судалсан байх хөтөлбөрт тусгагдсан судлагдахуун бүрэн эсэхийг шалгах.
- Ангийн бүх суралцагчийн төлөв **Идэвхтэй**, баталгаажуулалтын төлөв **Батлагдсан** байх.

Судлагдахууны дүн бодохдоо батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр судалж дүн, үнэлгээ тавигдсан хичээлийн эцсийн үнэлгээгээр бодож байгаа болно.

Сонгон, мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээлийн хувьд судлагдахууны дүн бодогдсон сонгон болон мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээлийн хамгийн өндөр үнэлгээтэй хичээлийн дүнг бүртгэлийн маягтад гаргаж байгаа болно.

Сурлагын үнэлгээний дундаж хувь:

Энэхүү үнэлгээг Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2019 оны №А/46 тушаалаар батлагдсан суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлалаар системээсээ бодож харуулж байгаа болно.

Боловсролын баримт бичигт тавигдах хичээлийн нэрс, дүн үнэлгээг бүртгэлийн маягтаар хянах боломжтой.

Дараах үйлдлийг хийж сурлагын үнэлгээний дундаж хувийг хянаана.

- Боловсролын тухайн түвшний буюу суурь, бүрэн дунд боловсролд заавал үзэх хичээл, сонгон болон мэргэжлийн/гүнзгийрүүлэн судалсан хичээлийн дүнг оруулж баталгаажуулсан байх
- Судлагдахууны дүн, үнэлгээг бодуулж баталгаажуулсан байх
- Төгсөлтийн бүртгэлийг хийх /зөвхөн бүртгэл хийж, бүх мэдээллийг хянасны дараа илгээх/
- Бүртгэлийн маягт татах /бүртгэлийн маягтыг татсанаар суралцагч бүрийн сурлагын үнэлгээний дундаж бодох буюу эксэл рүү гаргаж мэдээллийг нягтлан хянах боломжтой.

3.3 Судлагдахууны дүн баталгаажуулах хүсэлт илгээх

3.3. Судлагдахууны дүн баталгаажуулах хүсэлт илгээх

Судлагдахуун бүрээр суралцагчийн судлагдахууны дүнг илгээх үйлдэл юм. Энэ үйлдлийг хийснээр хүсэлт илгээсэн судлагдахууны хувьд суралцагчийн судлагдахууны дүн **хүлээгдэж байгаа** төлөвт орно. Хүлээгдэж байгаа төлөвт орсон дүнг засах боломжгүй байх бөгөөд засах шаардлагатай бол **сургалтын менежер**т мэдэгдэн хүсэлтийг **цуцлуулах** шаардлагатай.

Баталгаажуулах хүсэлт илгээх алхам:

1.

Анхаарах зүйлс:

1. Баталгаажуулах хүсэлт илгээх товч дарахаас өмнө сонгоогүй суралцагч үлдсэн эсэхийг шалгах
2. Судлагдахуун бүрээр бүх суралцагчийн дүнг илгээсэн эсэхийг шалгах

(Илгээсэн бол **хүлээгдэж байгаа** төлөвт орсон байна.)

3. Судлагдахууны дүн нь бодогдоогүй суралцагчийн дүн илгээгдсэн байгаа эсэхийг шалгах

3.4 Тушаал, журам



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

「Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж
хувь бодох аргачлал батлах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар батлагдсан "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам"-ын 4 дүгээр хэсгийн 4.6.5 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Боловсролын үнэлгээний төвийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ш.Шижир-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАН-ЭРДЭНЭ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 07 сарын 25-ны
өдрийн 3967 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.
3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.
4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.
5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.
6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам, загвар шинэчлэн батлах тухай" А/309 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0001553

3.5 Бүртгэлийн маягт

Бүртгэлийн маягт

2018-2019 оны хичээлийн жилд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн боловсролын баримт бичиг дээр тавигдах хичээлийн дүн, үнэлгээ /заавал, сонгон, мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл болон улсын шалгалт/ болон сурлагын үнэлгээний дундаж, боловсролын баримт бичгийн дугаар зэрэг мэдээллийг харуулна.

Суралцагчийн дараах мэдээллийг шалгана.

- Хичээлийн дүн, үнэлгээ болон 7хоногт судалсан цаг
 - Заавал судалсан хичээл (Тухайн түвшний болон өмнөх анги)
 - Сонгон судалсан хичээл (зөвхөн судалсан хичээл)
 - Мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл (зөвхөн судалсан хичээл)
 - Улсын шалгалтын дүн
- Суралцагчийн хувийн мэдээлэл
 - Овог
 - Нэр
 - Регистр
- Сурлагын үнэлгээний дундаж хувь
- Боловсролын баримт бичгийн дугаар (гэрчилгээ болон үнэмлэх)

Дараалал:

1. Суралцагчийн судалсан **хичээлийн дүн** /үнэлгээ/, 7 хоногт судалсан цаг

- Заавал судалсан хичээл (9 анги бол 6-9 ангийн, 12 анги бол 10-12 ангид сургалтын төлөвлөгөөгөөр заавал судалсан хичээл)
 - Дүн, үнэлгээ өмнө оруулсан бол системээс харуулна. Байхгүй бол нөхөж оруулна
 - Батлагдсан сургалтын төлөвлөгөө дахь цагаар цагийн мэдээллийг засах боломжгүйгээр системээс харуулна.
- Сонгон болон мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл
 - Дүн, үнэлгээ өмнө оруулсан бол системээс харуулна. Байхгүй бол нөхөж оруулна
 - Батлагдсан сургалтын төлөвлөгөө дахь цагаар цагийн мэдээллийг засах боломжтойгоор системээс харуулна

2. Судлагдахууны дүн бодуулж, баталгаажуулах

- Заавал судалсан хичээл (Хичээлийн эцсийн үнэлгээгээр бодож харуулна.)
- Сонгон болон мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл (Хичээлийн эцсийн үнэлгээгээр бодож харуулна.)

3. Төгсөлтийн бүртгэл хийх

Зөвхөн төгсөлтийн бүртгэлийн хийнэ. Бүртгэлийн маягтаар суралцагч бүрийн мэдээллийг хянаж, алдаагүй гэж үзсэн үедээ баталгаажуулах хүэлт илгээнэ.

4. Бүртгэлийн маягт татах

Бүртгэлийн маягт татсанаар боловсролын баримт бичигт тавигдах хичээлийн дүн, үнэлгээнээс суралцагч бүрийн сурлагын үнэлгээний дундаж хувийг бодож харуулна.

5. Төгсөлтийг баталгаажуулахаар илгээх

Суралцагчийн мэдээлэл алдаагүй, бүрэн гарсан гэж үзвэл сургалтын менежер мэдээллийг баталгаажуулахаар илгээнэ.

6. Мэргэжилтэн хянаж илгээх үйлдэл хийх

Мэргэжилтэн эрхээрээ мэдээллийг хянаж илгээх болон тодруулах, алдаатай гэж үзсэн тохиолдолд цуцлах үйлдлийг хийнэ.

7. БСУГ болон Боловсролын хэлтсийн дарга хянаж, баталгаажуулна.

Мэргэжилтний хянаж илгээсэн мэдээллийг дарга es31.. эрхээрээ хянаж цуцлах болон баталгаажуулах үйлдлийг хийнэ. Баталгаажуулснаар системээс суралцагч бүрт боловсролын баримт бичгийн дугаар олгогдож үнэт цаас дээр мэдээлэл хэвлэгдэх эрх нээгдэнэ.

8. Үнэт цаасны дугаар хуваарилах

Ангийн багш төгсөх суралцагч нэг бүрт үнэт цаасны дугаарыг системээр хуваарилж өгнө.

9. Хэвлэх

Хэвлэх үйлдлээр суралцагч нэг бүрийн мэдээллийг үнэт цаасанд хэвлэх загвар байдлаар системээс харуулна. Загвар хэвлэх буюу ноорог байдлаар дадлага хийж хэвлэж болох бөгөөд суралцагчийн бүх мэдээллийг хянаж, алдаагүй зөв болсон гэж үзвэл үнэт цаас дээрээ ногоон **ХЭВЛЭХ** товчоор хэвлэнэ.
